



“АСБИ” ХУВЬЦААТ КОМПАНИ ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2026 оны 03 сарын 21 өдөр

Дугаар 02.

Улаанбаатар хот

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал хуралдуулах тухай

Компанийн тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.4, 60 дугаар зүйл, Төлөөлөн удирдах зөвлөлийн 2026 оны 03 сарын 21-ний өдрийн хурлын шийдвэрийг үндэслэн ТОГТООХ нь:

1. АСБИ хувьцаат компанийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2026 оны 04 сарын 30-ны өдрийн Пүрэв гаригт 12.00 цагт компанийн оффисын байранд хуралдуулсугай.
2. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар дараах асуудлыг хэлэлцүүлсүгэй. Үүнд:
 1. Компанийн 2025 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийгдсэн хараат бус аудиторын дүгнэлтийг танилцуулах
 2. Компанийн 2025 оны санхүүгийн тайлангийн талаархи ТУЗ-ийн дүгнэлтийг хэлэлцэн батлах
 3. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох
 4. Гүйцэтгэх удирдлага болон ТУЗ-ийн 2026 оны зардлын төсөв батлах
3. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2026 оны 04 сарын 15-ны өдрөөр тогтоосугай.
4. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын товыг 2026 оны 03 сарын 26-ны өдөр, 2026 оны 04 сарын 10-ны өдөр тус тус Санхүүгийн зохицуулах хорооны 2018 оны 377 дугаар тогтоолоор баталсан “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам”-д заасныг баримтлан олон нийтэд зарласугай.
5. Хувьцаа эзэмшигчдийн танилцах бичиг баримтын жагсаалтыг 1 дүгээр хавсралтаар, олон нийтийн мэдээллийн хэрэгсэлээр зарлах хэвлэлийн эхийг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.
6. Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэх асуудал, гарах шийдвэрийн төсөл, түүнтэй холбогдох баримт бичгийг 2026 оны 03 сарын 31-ний өдөр бэлэн болгож, хувьцаа эзэмшигчдэд үйлчилж буй брокер диллерийн компаниудад цахим хэлбэрээр хүргүүлсүгэй.
7. Хувьцаа эзэмшигчдийн хурлын саналын хуудасыг 3а, 3б дугаар хавсралтаар баталж, саналын хуудасыг хүлээж авах сүүлчийн өдрийг 2026 оны 04 сарын 15-ны өдрийн 18.00 цагаар тогтоосугай.
8. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын даргаар Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга Д.Лхагвасүрэн, тооллогын комиссын даргаар М.Сугармаа, гишүүдээр Д.Энхжаргал, Д.Гантуяа нарыг тус тус томилсугай.



Д.ЛХАГВАСҮРЭН

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН МЭДЭГДЭЛ

Компанийн нэр:	“АСБИ” ХК
Хаяг:	Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 20-р хороо, Үйлдвэрийн баруун бүс, Ажилчны гудамж 51/1 тоот Компанийн оффисын байр, Утас: 70000198, 90955995
Хурал хуралдах өдөр, цаг:	2026 оны 04 сарын 30-ны өдрийн 12.00 цагт
Хурал хуралдах газар /хаяг, байршил/:	Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 20-р хороо, Үйлдвэрийн баруун бүс, Ажилчны гудамж 51/1 тоот Компанийн оффисын байр, Утас: 70000198, 90955995
Хурлын төрөл:	Ээлжит
Хурал зарлагч:	Төлөөлөн удирдах зөвлөл
Хурал хуралдах шийдвэр гаргасан огноо:	2026 оны 03 сарын 21 өдөр
Олон нийтэд зарлах огноо:	2026 оны 03 сарын 26 өдөр, 2026 оны 04 сарын 10 өдөр
Бүртгэлийн өдөр:	2026 оны 04 сарын 15 өдөр
Гэрээний дагуу хурлын баримт бичгийг брокер, дилерийн компанид хүргүүлэх огноо:	2026 оны 03 сарын 31 өдөр
Хүргүүлсэн огноо:	
Хурлын даргын нэр:	ТУЗ-ийн дарга Д.Лхагвасүрэн
Тооллогын комиссын дарга, гишүүдийн нэр:	Дарга: С.Сугармаа, Д.Энхжаргал, Д.Гантуяа
Баримт бичгийн жагсаалт /хавсралтаар/:	
Баримт бичгийн хуудасны тоо:	 ширхэг хуудас

УЛААНБААТАР ХОТ
ХУРАЛ ЭЗЭМШИГЧДИЙН БАЙГУУЛАХ КОМИССЫН ДАРГА
АСБИ
ХК
2026 оны 03 дугаар сарын 21-ний өдөр
Д.СҮМБАНД/